

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/200/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОУБ	Олон улсын байгууллага



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/88
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ХУНТОГОС ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020308

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,317,605.32</u>	<u>60,611,960.32</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	60,317,605.32	60,611,960.32
351	Түүхий эд материал	42,461,032.32	40,871,032.32
35110	Тусгай зориулалттай материал	42,461,032.32	40,871,032.32
354	Хангамжийн материал	17,856,573.00	19,740,928.00
35410	Бичиг хэргийн материал	24,000.00	650,600.00
35420	Аж ахуйн материал	17,655,573.00	18,866,810.00
35450	Барилгын засварын материал	135,000.00	135,000.00
35460	Хүнсний материал	42,000.00	88,518.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,288,457,716.48</u>	<u>1,360,965,819.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,288,457,716.48	1,360,965,819.12
392	Биет хөрөнгө	1,288,391,716.48	1,360,932,819.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,276,113,399.08	1,353,953,143.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-78,067,722.81	-105,083,464.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	143,476,808.00	149,425,729.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-107,160,624.03	-115,139,444.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,471,812.33	87,031,444.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-40,106,581.11	-45,030,318.46
39217	Ном	24,664,625.02	35,775,728.81
393	Биет бус хөрөнгө	66,000.00	33,000.00
39301	Програм хангамж	730,000.00	730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-664,000.00	-697,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,348,775,321.80</u>	<u>1,421,577,779.44</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,348,775,321.80</u>	<u>1,421,577,779.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,348,775,321.80	1,421,577,779.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	331,655,608.50	331,655,608.50
51101	Өмч: - төрийн	331,655,608.50	331,655,608.50
512	Хуримтлагдсан үр дүн	638,308,256.26	711,276,847.90
51210	Өмнөх үеийн үр дүн	638,308,256.26	638,474,390.26
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	72,802,457.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	378,811,457.04	378,645,323.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,348,775,321.80</u>	<u>1,421,577,779.44</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	928,665,602.91	1,057,810,140.54	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	733,340,502.91	113,273,169.54	
120	Нийтлэг татварын бус орлого	9,217,702.91	113,273,169.54	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,217,702.91	113,273,169.54	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,217,702.91	113,273,169.54	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	724,122,800.00	00.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	724,122,800.00	00.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	195,325,100.00	235,143,371.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	709,393,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,252,600.00	63,156,371.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,252,600.00	63,156,371.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	172,072,500.00	171,987,000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	172,072,500.00	171,987,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	961,051,255.90	985,007,682.90	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	961,051,255.90	984,942,140.87	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	874,978,227.82	909,956,392.20	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,315,515.81	578,225,611.61	
210101	Үндсэн цалин	570,315,515.81	326,923,743.38	
210102	Нэмэгдэл	00.00	155,465,432.33	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	8,526,000.50	
210104	Урамшуулал	00.00	87,310,435.40	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,906,475.11	75,952,323.86	
210201	Тэтгэврийн даатгал	49,546,546.11	52,486,523.73	
210202	Тэтгэмжийн даатгал	5,466,988.00	6,055,160.64	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,580,715.00	4,651,801.60	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,119,294.00	1,131,522.47	
210205	Эрүүл мэндийн даатгал	11,192,932.00	11,627,315.42	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,107,604.00	165,567,386.86	
210301	Гэрэл, цахилгаан	27,352,269.00	27,035,432.86	
210302	Түлш, халаалт	126,642,085.00	133,166,440.00	
210303	Цэвэр, бохир ус	6,113,250.00	5,365,514.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	8,699,816.00	13,162,600.00	
210401	Бичиг хэрэг	3,246,450.00	2,791,800.00	
210402	Тээвэр, шатахуун	195,000.00	361,200.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	271,489.00	300,080.00	
210404	Ном, хэвлэл	00.00	3,800.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	451,000.00	320,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,535,877.00	9,385,720.00	

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	13,198,810.00	31,474,682.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,800.00	39,850.00
210502	Хоол, хүнс	12,920,010.00	31,434,832.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	6,610.50
210602	Тавилга	00.00	6,610.50
210604	Урсгал засвар	750,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	816,000.00	33,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	816,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,184,006.90	45,534,177.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	310,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	489,200.00	620,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,384,806.90	44,914,177.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,073,028.08	74,985,748.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,887,600.00	58,599,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,971,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	24,735,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,916,600.00	33,864,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,697,510.08	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,697,510.08	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,487,918.00	5,505,113.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,487,918.00	5,505,113.14
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,880,935.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,880,264.53
213504	Хөрөнгийн	00.00	671.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	65,542.03
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	65,542.03
222001	Тоног төхөөрөмж	00.00	65,542.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-32,385,652.99	72,802,457.64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	72,227.21	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	72,227.21	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-72,227.21	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-32,457,880.20	72,802,457.64

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,655,608.50	378,933,294.36	670,638,550.46	1,381,227,453.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	127,586.00	127,586.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	331,655,608.50	378,933,294.36	670,766,136.46	1,381,355,039.32
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-32,457,880.20	-32,457,880.20
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,655,608.50	378,811,457.04	638,308,256.26	1,348,775,321.80
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,655,608.50	378,811,457.04	638,308,256.26	1,348,775,321.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	166,134.00	166,134.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	331,655,608.50	378,811,457.04	638,474,390.26	1,348,941,455.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-166,134.00	00.00	-166,134.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	72,802,457.64	72,802,457.64
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,655,608.50	378,645,323.04	711,276,847.90	1,421,577,779.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	919,447,900.00	944,622,471.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	724,122,800.00	85,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	85,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	85,500.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	724,122,800.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	724,122,800.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	195,325,100.00	944,536,971.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	709,393,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,252,600.00	63,156,371.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,252,600.00	63,156,371.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	172,072,500.00	171,987,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	172,072,500.00	171,987,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	917,080,000.00	939,787,871.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	917,080,000.00	939,787,871.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	830,163,171.92	842,495,722.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565,187,031.43	577,867,178.36
210101	Үндсэн цалин	429,082,252.48	333,242,062.33
210102	Нэмэгдэл	83,347,547.14	145,866,608.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,534,024.00	11,292,000.00
210104	Урамшуулал	41,223,207.81	87,466,507.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,034,959.49	76,310,757.11
210201	Тэтгэврийн даатгал	54,806,100.00	53,918,862.73
210202	Тэтгэмжийн даатгал	5,732,800.00	5,877,970.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,586,400.00	4,583,904.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,116,400.00	1,142,031.14
210205	Эрүүл мэндийн даатгал	10,793,259.49	10,787,987.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163,593,802.00	165,567,386.86
210301	Гэрэл, цахилгаан	29,958,107.00	27,035,432.86
210302	Түлш, халаалт	125,996,483.00	133,166,440.00
210303	Цэвэр, бохир ус	7,639,212.00	5,365,514.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,951,789.00	3,513,480.00
210401	Бичиг хэрэг	370,000.00	327,500.00
210402	Тээвэр, шатахуун	195,000.00	427,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	271,489.00	798,580.00
210404	Ном, хэвлэл	335,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,615,300.00	1,800,000.00
2105	Нормативт зардал	14,441,010.00	13,295,620.00

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	270,000.00	499,050.00
210502	Хоол, хүнс	12,962,010.00	9,998,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,209,000.00	2,798,260.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	990,780.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	990,780.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,102,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,102,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,861,800.00	4,941,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	388,000.00	1,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,473,800.00	3,541,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,916,828.08	97,292,148.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,731,400.00	80,906,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,894,800.00	21,483,040.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	24,735,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,916,600.00	33,864,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,000.00	823,360.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,185,428.08	5,505,113.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,185,428.08	5,505,113.14
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,880,935.53
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,880,264.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2,367,900.00</u>	<u>4,749,100.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>2,367,900.00</u>	<u>4,834,600.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>2,367,900.00</u>	<u>4,834,600.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	2,367,900.00	4,834,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,367,900.00	4,834,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,367,900.00</u>	<u>-4,834,600.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	881,466,100.00	865,080,682.33	16,385,417.67	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,466,100.00	865,080,682.33	16,385,417.67	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,507,000.00	842,774,282.33	13,732,717.67	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,601,900.00	577,867,178.36	2,734,721.64	99.5
210101	Үндсэн цалин	381,495,500.00	333,242,062.33	48,253,437.67	87.4
210102	Нэмэгдэл	142,186,400.00	145,866,608.91	(3,680,208.91)	102.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,216,000.00	11,292,000.00	6,924,000.00	62.0
210104	Урамшуулал	38,704,000.00	87,466,507.12	(48,762,507.12)	226.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,381,200.00	76,310,757.11	2,070,442.89	97.4
210201	Тэтгэврийн даатгал	55,157,100.00	53,918,862.73	1,238,237.27	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	5,805,900.00	5,877,970.90	(72,070.90)	101.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,644,800.00	4,583,904.71	60,895.29	98.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,161,200.00	1,142,031.14	19,168.86	98.3
210205	Эрүүл мэндийн даатгал	11,612,200.00	10,787,987.63	824,212.37	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,072,500.00	165,567,346.86	5,505,153.14	96.8
210301	Гэрэл, цахилгаан	28,025,200.00	27,035,432.86	989,767.14	96.5
210302	Түлш, халаалт	133,166,400.00	133,166,400.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	9,880,900.00	5,365,514.00	4,515,386.00	54.3
2104	Хангамж, бараа материалын зардал	4,345,000.00	4,112,580.00	232,420.00	94.7
210401	Бичиг хэрэг	450,000.00	327,500.00	122,500.00	72.8
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	427,400.00	72,600.00	85.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	798,580.00	1,420.00	99.8
210404	Ном, хэвлэл	335,000.00	299,100.00	35,900.00	89.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	160,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,100,000.00	2,100,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	15,948,400.00	13,295,620.00	2,652,780.00	83.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	499,050.00	950.00	99.8
210502	Хоол, хүнс	12,648,400.00	9,998,310.00	2,650,090.00	79.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.00	2,798,260.00	1,740.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,935,000.00	4,620,800.00	314,200.00	93.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,400,000.00	1,400,000.00	-	100.0

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,535,000.00	3,220,800.00	314,200.00	91.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,959,100.00	22,306,400.00	2,652,700.00	89.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,959,100.00	22,306,400.00	2,652,700.00	89.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,038,600.00	21,483,040.00	2,555,560.00	89.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.00	823,360.00	97,140.00	89.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	881,466,100.00	881,466,100.00	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	709,393,600.00	709,308,100.00	85,500.00	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	709,393,600.00	709,308,100.00	85,500.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	172,072,500.00	172,072,500.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	172,072,500.00	172,072,500.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	46.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,156,371.00	63,156,371.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,156,371.00	63,156,371.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,556,000.00	4,556,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	556,000.00	556,000.00
210401	Бичиг хэрэг	256,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,600,371.00	58,600,371.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,599,700.00	58,599,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,735,600.00	24,735,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,864,100.00	33,864,100.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	671.00	671.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	671.00	671.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,156,371.00	63,156,371.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,156,371.00	63,156,371.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,156,371.00	63,156,371.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжиж, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилган, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг эрхэм зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Захирлын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/10 дугаар “Дотоод хяналтын комисс байгуулах тухай” тушаалаар дотоод хяналтын багийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг боловсруулан баталсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын

алба хэрэгжүүлдэг байна. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 881,466.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,222.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,916.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 881,466.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 63,156.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 939,873.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 10,120.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 18,422.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 11,114.9 мянган төгрөгийн ном, нийт 39,658.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,834.6

мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 34,823.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 609.5 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 43,677.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 43,992.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Төв аймгийн Зуунмод сумын 4 дүгээр сургууль нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 60,611.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,283,120.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	-	-
Урьдчилгаа			-
Бараа материал	60,317.61	60,611.96	294.35
Үндсэн хөрөнгө	1,288,457.71	1,360,965.82	72,508.11
Нийт хөрөнгө	1,348,775.32	1,421,577.78	72,802.46
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,348,775.32	1,421,577.78	72,802.46
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,348,775.32	1,421,577.78	72,802.46

Бараа материалын дансны үлдэгдэл 60,611.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 294.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,360,965.8 мянган төгрөг болж 72,508.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,421,577.8 мянган төгрөг болж 72,802.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс хамаарч байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 881,466.1 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 856,507.0 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 24,959.1 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 856,507.0 мянган төгрөгийн урсгал зардал, 24,959.1 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 881,466.1 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 865,080.7 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 16,385.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 865,080.7 мянган төгрөг буюу 98.1 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 63,156.4 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний зардалд 4,556.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 58,600.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 10,120.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 18,422.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 11,114.9 мянган төгрөгийн ном, нийт 39,658.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,834.6 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 34,823.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Дэлхийн Зөн ОУБ-ын Орон нутгийн хөтөлбөрөөс хийгдсэн 77,839.7 мянган төгрөгийн Номын сангийн засварыг орлогоор бүртгээгүй, санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүйг аудитын явцад залруулсан.

Тайлант хугацааны худалдан авалтыг и-баримттай тулгахад харилцагч байгууллагатай хийсэн 3,182.4 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүйг завсрын аудитаар илрүүлж, жилийн эцсээр зөрчлийг арилган ажилласан.

3.8 Аудитын гол асуудал

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 16 нэр төрлийн 8,673.6 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 126 нэр төрлийн 81,819.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 12 удаагийн нийт 187,267.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй, тайлант хугацаанд бичиг хэргийн зардлаас 256.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 124 мэдээллийг хугацаандаа, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг мэдээлээгүй, Цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 12 удаагийн нийт 187,267.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,673.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 алдаа зөрчил тайлант онд давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 356,257.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 77,839.7 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 277,761.3 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 656.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 77,839.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

1. Дэлхийн Зөн ОУБ-ын Орон нутгийн хөтөлбөрөөс хийгдсэн 77,839.7 мянган төгрөгийн номын сангийн засварыг орлогоор бүртгээгүй, санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 16 нэр төрлийн 8,673.6 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэх, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 126 нэр төрлийн 81,819.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Цалингаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш 12 удаагийн нийт 187,267.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн

тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 400.0 мянган төгрөгийн үнэ бүхий биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд бичиг хэргийн зардлаас 256.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвий тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 124 мэдээллийг хугацаандаа, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	7	356,257.0	1	77,839.7	-	-	3	277,761.3	3	656.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn